МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 26 өдөр Дугаар А/196 Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Харилцаа холбооны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 499 дүгээр тогтоол, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын 2.1.3, Аймгийн Засаг даргын Зөвлөлийн 2024 оны 04 дүгээр сарын 17-ний өдрийн 14 дүгээр хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөвсгөл аймагт Төрийн цахим үйлчилгээний Хурдан цэгийг Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төвд шинээр байгуулахад шаардлагатай Брендбүүк тохижилтын зардалд 3,660,000 (Гурван сая зургаан зуун жаран мянга) төгрөгийг Эрх зүй нийгмийн хэв журам хөтөлбөрийн Засаг даргад хуулиар олгосон үүрэг, эрх хэмжээний хүрээнд захиран зарцуулах, мөн мөрийн хөтөлбөрийн хэрэгжилт хангах арга хэмжээний зардлаас, Монгол улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны хамтран зохион байгуулж буй "Цахимд хэвшье-Digital First D1" арга хэмжээг зохион байгуулах арга хэмжээний зардал 10,432.000 (Арван сая дөрвөн зуун гучин хоёр мянга) төгрөгийг Төрийн албаны ерөнхий удирдлага зохицуулалт хөтөлбөрийн Цахим аймаг хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд мэдээллийн аюулгүй байдлын үзүүлэлт сайжруулах арга хэмжээний зардлаас тус тус зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Батбилгүүн)-д зөвшөөрсүгэй.

2.Батлагдсан хөрөнгийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зориулалтын дагуу зарцуулж, гүйцэтгэлийг тайлагнаж ажиллахыг Төрийн цахим үйлчилгээний хэлтэс (Д.Сумаадагва)-д үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д даалгасугай.

ДАРГА П.ЛХАГВАЖАВ

Захирамж2024

6712010600